



ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЦЭЦЭРЛЭГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 15 өдөр

Дугаар А/45

Халбан

Мал, амьтныг халдварт, шимэгчтэх өвчнөөс урьдчилан  
сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх заалт, 59.1.23 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, 6.4 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэг, 9.5 дахь хэсэг, 9.6 дахь хэсэг, 9.8 дахь хэсэг, 34 дүгээр зүйлийн 34.2.4 дахь заалт, Хөвсгөл аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 24 -ны өдрийн А/26 тоот захирамж зэргийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын хэмжээнд халдварт, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг голомтын судалгаанд үндэслэн технологийн хугацаанд чанартай зохион байгуулж ажиллахыг "Баялаг үйл- Ундрах" мал эмнэлгийн Захирал, Малын эмч (М.Баатаржав), "Таг дүүрэн сүрэг" мал эмнэлгийн Захирал, Малын эмч (Н.Доржжүгдэр) бусад эмч мэргэжилтэн нарт үүрэг болгосугай.

2.Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар олгогддог халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний вакцин, био бэлдмэлийн багуудын малын тоонд харьцуулсан хуваарийг 1 дүгээр хавсралтаар, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг бүх багийн Засаг дарга, баг хариуцсан гэрээт Малын эмч нарт даалгасугай. Үүнд:

3.1.Харьяа багийнхаа нутаг дэвсгэрт мал амьтныг халдварт, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалт, угаалга, туулгалт, боловсруулалт, тандалт шинжилгээ зэрэг төвлөрсөн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд баг хариуцсан гэрээт малын эмчтэйгээ нягт хамтран ажиллаж зохион байгуулалтын болон санхүүгийн дэмжлэг үзүүлж ажиллах,

3.2.Мал угаалгын суурин ванн, ажил үйлчилгээний нэг цэгийн болон зөөврийн төмөр хашааны ашиглалтыг сайжруулж засаж сэлбэх, шинээр бий болгох зэрэг бүтээн байгуулалтын ажлуудыг гэрээт малын эмч, багаас сонгогдсон сумын Иргэдийн

Төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчид, малчидтайгаа хамтран шийдвэрлэх зохион байгуулалтын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх,

3.3. Мал сүргийг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад голомт бүхий газар нутагт байгаа мал сүргийг бүрэн хамруулсан эсэхэд хяналт тавьж мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллахыг мал эмнэлгийн тасгийн дарга, мал эмнэлгийн хяналтын Улсын Байцаагч (Н.Алтанхуяг)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Бямбажав)-т үүрэг болгосугай.

ДАРГА  Н.АНХБАЯР

